

IV ШАШИН СУДЛАЛ

“БОДЬ” ХЭМЭЭХ ОЙЛГОЛТЫН ТУХАЙ БУДДЫН СУРГААЛ

М.Гантуяа

МУИС-ийн Буддын ба Санскрит Судлалын Төв

Түлхүүр үг: Чинад мэдлэг, хуран эс үүдсэн ном, дхармын онол, билиг билгүүний бие, хувилгаан бие.

Товч утга: Бодь гэдэг нь сэтгэлийн хир, нисванисыг дарж, зовлонт сансарын хүрдэнд эргэж төрөхөө нэгэнт больсон, ухаан билгийн дээдэд хүрсэн бодгалийг илэрхийлдэг ойлголт. Буддын сургаалд Бодь мод, Бодь сэтгэл, Бодь зүрхэн гэх мэт Бодийг тойрсон олон асуудлыг хэлэлцдэг. Эдгээрээс “Бодь зүг” гэдэг ойлголт нь Бодь-д буюу гэгээрэлд байх, түүнтэй хамт илрэх чанарууд, асуудлууд, сэдвүүд гэсэн утгыг илэрхийлдэг байна. Бодь зүгийн номууд нь бие хүн буюу бодгалийн бүрэлдэхүүнд ордог зайлшгүй хэсэг, элементүүдийн тоонд багтдаг ажээ. Ингэхлээр гэгээрсэн бурханд байх чанарууд нь жирийн хүмүүст, бүх төрөлхтөнд байдаг, гагцхүү зовлонг төрүүлэгч чанаруудыг дарж устган, бодь зүгийн номуудыг илрүүлэх асуудал л Буддын сургаалын зорилго болж байгаа юм.

Монголын Буддын философийн сэтгэлгээнд Төвдийн Гелүмба ёсны сургаал, Их хөлгөний философи давамгайлсан талаар судлаачид олонтаа дурдан үндэс баримт гаргасан байдаг. Харин Их хөлгөний философийг үүсгэгч их багш Нагаржуна болон Асанга, Васубанду нарын амьдарч байсан үеэс өмнөх эртний Энэтхэгийн болон Бага хөлгөний философи сэтгэлгээний уламжлал хэрхэн нөлөөлсөн асуудал судалгаагаар тэр бүр тодорхой гардаггүй. Нөгөөтэйгүүр, судалгаа нь гол төлөв Буддын төвд, монгол хэлт бүтээлүүд байдаг учраас эртний санскрит хэлт сурвалжуудын харилцаа холбооны асуудал ч орхигдох хандлагатай болжээ.

Буддын Их, Бага хөлгөний философийн онолын үзэл баримтлалын уялдаа холбоог Авидарма болон Билиг барамидын сургаалын харьцуулсан шинжилгээгээр гаргаж болно. Монголын Буддын философийн эдгээр бүрэлдэхүүн хэсэг нь анхан эртний Энэтхэгийн Буддизмыг сүүл үеийн Төвд, Монголын Буддизмтай холбож байгаа гол гүүр хэсэг гэж хэлж болмоор

байгаа юм. Авидарма болон Билиг барамидын сургаалын хүрээнд авч үздэг философийн ойлголт ухагдахуунууд гарал үүслээрээ ямагт нэн эртний Энэтхэгийн философи сэтгэлгээнд холбогддог. Энд яригдаж байгаа ойлголтуудын гарал үүсэл, түүхэн хөгжлийг тэдгээрийн эртний Энэтхэгийн Вед болон бусад философийн сургаалуудад хэрхэн тайлбарлаж ирсэн, улмаар Буддын сургаалд ямар үндэслэлээр тэдгээр ойлголтыг авч хэрэглэсэн, ямар шинэ тайлбар үзэл баримтлал дэвшүүлснийг гаргаснаар Авидарма болон Билиг барамидын сургаалын үзэл санааны мөн чанар улам тодорхой болж, ерөөс Их, Бага хөлгөний сургаалын ялгаа болон уялдаа холбоог нарийвчлан тогтоох боломж бүрдэх учиртай.

Их хөлгөний сургаал үүсэхэд зайлшгүй нөлөөлсөн нэг чухал үзэл нь **“Бодь”** хэмээх ойлголтыг тойрсон үй түмэн асуудал байдаг. Бодь (санскритээр *Bodhi*, төвдөөр *byang chub*) гэсэн үг нь эртний Ведийн сударт *“bodhin manas”* буюу “гүн нарийн ухаан”, “гүн сэтгэлгээ” гэсэн утгыг илэрхийлдэг¹ байна. Харин Буддын сургаалд “Бодь” гэсэн ойлголтыг “дээд мэдлэг”, “төгс гэгээрэл”, “боловсорсон ухаан билиг” гэх мэт утгаар² хэрэглэдэг. Гэгээрэлд бүрэн хүрсэн төрөлхтөнийг (хүнийг) Будда (Buddha) гэнэ. *Bodhi* ба *Buddha* гэсэн хоёр үг нь “*Budh*” гэсэн нэг үндэстэй, ухаар-, гэгээр-, сэхээр-, сэргэ-, сэтгэ- гэх мэт утгыг агуулдаг байна. Орчин үеийн дэлхийн Буддын судлалд нэрд гарсан эрдэмтэн судлаач Д.Т.Сузуки “Бодь” хэмээх ойлголтыг “Номын бие” (*Dharma-kaya, chos-sku*) гэсэн ойлголттой салшгүй холбоотой гэж үзсэн байдаг бол Хар Даяалын үзэж байгаагаар *Kaya* (бие, *sku*) гэсэн ойлголт нь Буддын сургаалд *bodhi* гэсэн ойлголтоос сүүлд үүссэн³ хэмээн гарал үүслийн ялгааг заажээ. Билиг барамидын хөгжлийн нэлээд төлөвшсөн үеийн сурвалж болох Илт онолын чимэгийн нэгэн Энэтхэг тайлбарт дурдсанаар: “Номын биеийн үйлийн зүйл хэдүй буй хэмээвээс: [1] амьтан нугуудыг амарлихын үйл хийгээд [2] дөрвөн хураангуй нугуудад зохиохуй ба [3] хотлоос нисванис сэлтийн маш арилсныг онуулагч хийгээд [4] мөн чанар ямар мэт амьтны тус ба [5] зургаан барамид лугаа [6] бурханы мөр хийгээд [7] өвөрчлөнгөөр хоосон чанар лугаа [8] ангид бус ба [9] дохио лугаа [10] зоригдош үгүй хийгээд [11] биетэн нүгүүдийг огоот боловсруулахуй ба [12] бодьсатва нь мөрөөр илт шуналыг хариулах хийгээд [13] бодийг олох ба [14] ялгуусныг орон тийн арилсан ба [15] магтсан хийгээд [16] амьтны тус нь цаглашгүй хийгээд [17] бурханы шүтэхүй тэргүүтний эрдэм ба [18] бодийн гишүүн хийгээд [19] үйл нүгүүдийг үл

хомсдохуй хийгээд [20] үнэнийг үзэх ба [21] тэдрү бурууг тэвчих хийгээд [22] тэр орон үгүйн ёс ба [23] тийн бээр арилсан чуулган [24] хуран үүдсэн, [25] хуран эс үүдсэнд ангид бус бээр огоот мэдэх хийгээд [26] гаслангаас нөгчсөнөө зохиох лугаа [27] номын биеийн үйл үгүй хорин долоон зүйлд таалвай хэмээн номлосон болой"⁴. Энд Бодийг олох, Бодийн гишүүн зэрэг ойлголтыг Номын биеийн бүрэлдэхүүнд багтаан авч үзсэн, өөрөөр хэлбэл Номын бие нь Бодь гэсэн ойлголтоос илүү өргөн утгатай, багтаамжаараа ялгаатай ойлголтууд болох нь харагдаж байна.

Буддын сургаалын гол зорилго нь төрөлхтнийг зовлонгоос ангижруулах, чингэхдээ өөрийнх нь сэтгэлийг засаж, ухаан билгийг нь хөгжүүлэх аргаар зовлонгоос гэтэлгэх явдал байдаг. Өөрөөр хэлбэл, хүн их юм мэдснээрээ бус, харин зөв бодож сэтгэж, ухаарч чадсанаар зовлонгоос буюу аливаа зөрчил тэмцлээс ангид байж чадна гэж үздэг байна. Зөв сэтгэлгээ, зөв ухаарлыг бий болгох аргазүйн асуудал нь Энэтхэгт бүр Буддизм үүсэхээс өмнө тавигдсан байсан бөгөөд Буддын сургаал тэдгээрийг уламжлан хөгжүүлсэн байна. Зөв ухаарал, зөв бодол, зөв сэтгэлгээ гэдэг нь мэдээж логик зөв сэтгэлгээ мөн боловч ёс суртахууны алдаа нь ямагт логик зөв сэтгэлгээг гажуудалд оруулдаг гэж үзэх учраас зөв сэтгэлгээ нь зөв үйл, зөв амьдрал, зөв үг яриа, тэр ч бүү хэл зөв хооллолт, эрүүл мэндтэй салшгүй холбоотой бүрэлдэнэ хэмээх үзлийг зөвхөн Буддизмд төдийгүй Энэтхэгийн философийн Буддын бус урсгал чиглэл (гадаад тогтсон таалал), ялангуяа Йогийн ёсонд хүлээн зөвшөөрдөг юм. Зовлонгоос, зөрчил хямралаас ангижрахад танин мэдэхүйн арга, сэтгэлзүй, эрүүл мэнд, аж төрөх ёс зэрэг нэн олон хүчин нөлөөлдөг тухай Буддын сургаалд заана. Энэ бүхнийг цогцоор нь бүрдүүлсний эцэст хүрэх үр дүнгийн асуудал нь Буддын философийн нэлээд төвөгтэй асуудлын нэг байдаг.

Буддын анхан эртний сургаал ёсоор зовлонгоос гэтэлсэн төрөлхтөн нь Нирванд (Nirvana) хүрнэ гэнэ. Nirvana гэсэн ойлголтыг Буддизмд эртний Ведийн ёсны Бярман (Brahman)-ы үзэл санаанд сөргүүлэн гаргаж ирсэн тухай олон судлаач дурдсан байдаг. Nirvana гэсэн үг нь сүүл үеийн Упанишад (Upanishad), Йогийн (Yoga) болон Тоотны (Samkhya) сурвалжид бясалгал үйл ажиллагааны төгсгөлийг илэрхийлж, устсан, унтарсан, дуусаж төгссөн, хөдөлгөөн нь зогссон, төгсгөл, бариа, сүүлчийн үр дүн гэх мэт утгаар хэрэглэгдэж иржээ. Харин Жайны (Jaina) болон Буддын сургаалд маш чухал ойлголтын үүрэг гүйцэтгэх болсон юм⁵. Энд Nirvana нь хүсэл

тэмүүлэл, сэтгэл хөдлөлийн эсрэг утгыг илэрхийлж аливаа сэтгэлийн хөдөлгөөний зогсолт, зовлонгийн төгсгөлийг заана. Сэтгэлийн хөдөлгөөн нь сэтгэлийг хямрал зовлонд оруулах гол хүчин зүйл гэж үзэх учраас анхан эртний Буддизмд сэтгэлийн хөдөлгөөнөө зогсоож Нирван болохыг гол зорилго хэмээн сургаж байжээ.

Гэвч Буддын сургаалын зорилго нь Нирванд хүргэж сэтгэл санаа, оюун ухааны хөгжлийг зогсоох явдал бус гэдгийг анхнаасаа л сургасан юм. Жирийн хүнээс чанарын ялгаатай сэтгэлийн төлөв болох Нирванд болон Бодийн чанарыг бүрэн гүйцэд олох хүртэл бясалгалын маш олон шатны сургалтыг тасралтгүй номлож ирсэн байдаг. Чухам Нирванаас хойшхи сэтгэлийн гэгээрэл, Бодь сэтгэл номлох болсноор Буддын сургаал Бага хөлгөнөөс Их хөлгөнд шилжсэн гэж үзэж болно. Гэхдээ Буддын анхан эртний сурвалжуудад Бодь хэмээх ойлголтын талаар өгүүлсэн зүйл арвин буй. Бага хөлгөний сурвалж гэгддэг Авидарма сурвалжид л гэхэд Бодь гэсэн ойлголтыг Нирваны талаархи ойлголттой нэлээд дөхүү тайлбарласан тал ажиглагддаг. Жишээ нь, эртний Энэтхэгийн их сэтгэгч Васубандугийн Авидарма тайлбар шастирт: "Барсан хийгээд үл төрөхүйг мэдэгч нь Бодь болой. Барсан хийгээд үл төрөхүйг мэдэгч нь бодгалийн ялгалаар Ширваны Бодь хийгээд Брадигабодийн Бодь ба дээр үгүй Үнэхээр туулсаны Бодь лугаа гурван Бодь хэмээх буюу. Тэр хоёроор мунхгийг хоцроол үгүй тэвчсэний тул хийгээд өөрийн тусыг үйлдэх ба тэвчигдэхүүн үгүй үнэнийг хэр мэт онохын тул болой"⁶ хэмээснээс үзэхүл Бодь гэдэг нь сэтгэлийн хир, нисванисыг дарж, зовлонт сансарын хүрдэнд эргэж төрөхөө нэгэнт больсон, ухаан билгийн дээдэд хүрсэн бодгалийг илэрхийлдэг байна.

Буддын сургаалд ухаан билгээ зовлон-зөрчилт сансарын хүрднээс арилгаж дээд амарлингуйд хүргэх бясалгал сургалтын зам мөрийг номлодог бөгөөд Чуулганы мөр, Барилдлагын мөр, Үзэхүй мөр, Бясалгал мөр, Үл суралцах мөр гэсэн дараалсан таван мөрийг туулж, сүүлчийн дээд амжилтыг тогтоодог буюу Нирванд хүрнэ. "Тэвчигдэхүүн хир бүгдийг арилгаад, оногдохуун эрдэм бүхнийг дотроо багтаасан Үл сурахуй мөрийг Бодь хэмээнэ"⁷ гэсэн нь дээрхи таван мөрийн сүүлчийн Үл суралцахуй мөр дээр "Бодийн" чанар бүрэлдэнэ гэсэн үг болно.

Буддын сургаалд Бодь мод, Бодь сэтгэл, Бодь зүрхэн гэх мэт Бодийг тойрсон олон асуудлыг хэлэлцдэг. Жишээ нь: "Бодь зүрхэн үл сэтгэгч адхаг нь бодийн зүрхэнээ сэтгэн үл үйлдмүй"⁸ хэмээн сэтгэлийн дээд амарлингуй

төлөвт хүрэхэд саад болох хүчин зүйлүүдийн нэг нь бодийн сэтгэл зүрхийг үл ухаарах явдал гэж тодорхойлжээ. Энэ мэт Бодийг тойрсон олон асуудлаас **“Бодь зүг”** гэсэн ойлголтын талаар дэлгэрүүлж авч үзье.

Монголоор “Бодь зүг” хэмээн орчуулсан энэ ойлголтыг санскритээр “Bodhi pakṣya”, төвдөөр “Byang chub phyogs” гэх бөгөөд “pakṣya” (зүг, phyog) нь Бодь-д буюу гэгээрэлд байх, түүнтэй хамт илрэх чанарууд, асуудлууд, сэдвүүд гэсэн утгыг илэрхийлдэг байна⁹. Бодь зүг гэсэн ойлголтыг Номын бие гэсэн ойлголтоос ялгаж: “...Хамаг зүйлийг айлдагч лугаа Номын бие хэмээн өгүүлсэн болой хэмээн номлосон мөн бөгөөд нөхцөл арилснаар Номын чанарын бие хэмээн өгүүлсэн бөлгөө. Бусдад ном нугуудын бие нь Номын бие хэмээх мөний тул мөн чанар арилснаа болох хийгээд эдлэхийн утга мөний тул хуран үүдснээ болохын гэм буй болой. Түүнээ бие хэмээн өгүүлсэн нь эртний ахуй учрыг дагаж чухал нэрийдсэн мөн хэмээн үлдвэй. Түүнд бодь зүг, дурдахуй чухал агуулах тэргүүтэн номлосон лугаа сэлтийн учрыг дэлгэрүүлэхүй мөрийн чуулганаас ямар хэмээн номлосон түүнчлэн мэт үйлдэхүй болой”¹⁰ хэмээжээ. Буддын сургаал дахь Ном хэмээх ойлголтын хамгийн ерөнхий түгээмэл утгыг Номын бие гэх ба харин таван мөрөөр суралцаж хамгийн дээд шатанд гарахад илрэх чанарыг Бодь зүг гэдэг байна. Буддын анхан эртний болон сүүл үеийн, мөн билиг барамидын болон Их хөлгөний судар шастируудад бодь зүгийн гучин долоон номын талаар нэлээд элбэг дурдсан байдаг.

Васубанду багшийн “Илт номын сангийн тайлбар”-т дурдсанаар:

“Бас номын цогцын хэмжээ хэдүй чинээ буюу хэмээвээс... [5] цогц хийгээд [12] төрөн түгэхүй ба [18] язгуур хийгээд [12] шүтэн барилдаж болсон ба [4] үнэн хийгээд нирван ба [4] дияан хийгээд цаглашгүй ба дүрс үгүй хийгээд тийн тонилсон ба сүрээр дарахын төрөн түгэх хийгээд барагдахын төрөн түгэх ба **бодь зүг лүгээ зохилдсон** [37] ба зөн билиг хийгээд өөр өөр үнэхээр ухахуй ба гүнээ мэдсэн лүгээ нисванис үгүй тэргүүтэн үгийн үндэс бүр дор номын цогц хэмээн өгүүлмү”¹¹. Цувиралт ба цувирал үгүйн бүх дхарм нэгдэж, нэгэн бодгалийг бүрдүүлэгч элементүүд буюу цогц номууд болдог талаар энд өгүүлээд түүний бүрэлдэхүүнд орох номуудыг тоочин нэрлэжээ. Ийнхүү **бодь зүгийн номууд** нь бие хүн буюу бодгалийн бүрэлдэхүүнд ордог зайлшгүй хэсэг, элементүүдийн тоонд багтдаг ажээ. Ингэхлээр гэгээрсэн бурханд байх чанарууд нь жирийн хүмүүст, бүх төрөлхтөнд байдаг, гагцхүү зовлонг төрүүлэгч чанаруудыг дарж

устган, бодь зүгийн номуудыг илрүүлэх асуудал л Буддын сургаалын зорилго болж байгаа юм.

Бодгалийг бүрдүүлэгч номуудын жагсаалтыг Билиг барамидын судар шастируудад ч заасан байдаг. Билиг барамидын анхны сурвалж болох монголчуудын дунд [Жадамба] (brgyad-stong-ba) хэмээх төвд нэрээрээ алдаршсан Найман мянган шүлэгт (Aṣṭaśhasrika Prasaparamita) сударт: Билиг барамидад суралцсанаар "дүрсэнд үл оршыюу, сэрэхүйд бус, сэтгэхүйд бус, үйлдэхүй нүгүүдэд бус, тийн мэдэхүйд үл оршыюу. Нүдэнд үл оршыюу, дүрсэнд үл оршыюу, нүдний тийн мэдэхүйд үл оршыюу, нүдний хуран хүрэлцэхүйд үл оршыюу, нүдний хуран хүрэлцэхүйгээс болсон сэрэхүйд үл оршыюу. Түүнчлэнхүү чих, хамар хийгээд хэл, бие хийгээд сэтгэлд үл оршыюу. Дуу, үнэр, амт, хүртэхүй хийгээд номууд ба чихний тийн мэдэхүйгээс сэтгэлийн тийн мэдэхүй хүртэл хийгээд сэтгэл хураад хүрэлцэхүйгээс болсон сэрэхүй хүртэл үл оршыюу. Шороон язгуурт үл оршыюу, усны язгуур, галын язгуур, хийн язгуур, огторгуйн язгуур хийгээд тийн мэдэхүйн язгуурт үл оршыюу. **Дурдахуй ойр агуулахуйд үл оршыюу. Үнэхээр тэвчихүй, рид хөл, эрхтэн, хүч, бодь мөр хийгээд мөрд үл оршыюу.** Үргэлжид оршсоны үрд үл оршыюу, нэгэнтээ харин ирэгчийн үр, харин үл ирэгчийн үр, дайныг дарсан бөгөөдөд үл оршыюу. Брадигабодид үл оршыюу. Бурханд үл оршыюу"¹² хэмээсэн буй.

Васубанду багшийн Авидарма тайлбар шастир болон Жадамба дахь дхармуудыг тоочин жагсаасан байдлаас харахад тэдгээр нь хоорондоо нэг их зарчмын зөрөөгүй мэт санагдана. Гэхдээ тухайлан авч үзэж байгаа асуудлаас шалтгаалан дхармын тоонд харилцан адилгүй жагсаалт гардаг. Васубандугийн шастирт л гэхэд цувиралт дхарм болон цувирал үгүйн дхармын алинд илүү анхаарч байгаагаас шалтгаалаад нөгөөг нь товч төдий тоочсоноос нийт тоо өөр өөр байх жишээтэй. Эхний бүлгүүдэд цувиралт дхармын асуудал гол болж байгаа учраас тэдгээрийг 75 хүртэл дэлгэрэнгүй тоолсон боловч цувирал үгүйн дхармуудыг ердөө 3 дхармд (өөр өөр шинжилсний түридгэл, өөр өөр бус шинжилсэний түридгэл, огторгуй) хураасан буй. Гэсэн хэдий ч Билиг барамидын судруудад цувирал үгүйн дхармуудад илүү өргөн жагсаалт гаргасан байдаг. Жишээ нь: Цувирал үгүйн ном нугууд нь дөрвөн дурдахуй чухал агуулсан хэмээхүйгээс бурханы эс хольцсон арван найман ном нугууд хэмээн алин бээр номлосон"¹³ гэдэг. Оросын Буддын судлаачид болон түүний нөлөөг илүү авсан бусад

орны, жишээ нь Эстоны судлаач Л.Мялль¹⁴ нар нэрт эрдэмтэн ф.И.Щербатской багшийнхаа судалгааг барьж Авидарма философид 78 дхармыг тоочсон хэмээн үзэх нь элбэг. Манай судлаач эрдэмтэн Г.Лхагвасүрэн ч энэ жишгээр тайлбарладаг. Үнэндээ наад зах нь бодь зүгийн 37 номыг тоочсон дээрхи жишээнээс л 78 дхармын тоо хамаагүй өсөх нь ойлгомжтой. Жадамба сударт болон ерөөс билиг барамидын судрууд цувирал үгүйн дхармуудад илүү анхаарлаа хандуулдгаас цувиралт 54, цувирал үгүй 56, нийт 110 дхармыг тоочсон талаар миний бие 1990-ээд оны судалгаандаа дурдсан билээ¹⁵. Гэхдээ нарийвчлан гаргавал энэ тоо Авидарма болон Билиг барамидын сурвалжуудад аль алинд нь нэлээд өсөх хандлагатай байгаа юм. Тухайлбал анхан эртний Авидармагийн үндсэн долоон судрын нэг "Тийн мэдэхүйн бие" хэмээх сурвалжид: "Бурхан багш Ананда шавьдаа (4 дурдахуй ойр агуулагч, 4 үнэхээр тэвчихүй, 4 рид хөл, 5 эрхтэн, 5 хүч, бодийн 7 гишүүн, хутагтын 8 мөр) 37 зүйлийг ямагт тайлбарлаж өгдөг байжээ"¹⁶ гэсэн бол Билиг барамидын сурвалжид тоочсоноор: "...мөнхүү билиг барамидыг бясалгах лугаа түүнчлэн сэрэхүй тэргүүтэн хийгээд нүдэн тэргүүтэн лүгээ дүрс тэргүүтэн ба нүдний мэдэл тэргүүтэн хийгээд түүнийг хурааж хүрэлцэх тэргүүтэн лүгээ түүнийг нөхцлөөр сэрэх тэргүүтэн хийгээд шороо тэргүүтнийг зургаан язгуур ба шүтэн барилдахуйд болсон хийгээд түүний гишүүн гаслан тэргүүтэн ба баримтлах лугаа анханаа тэргүүтний дияан нугууд хийгээд асрах ба нигүүлсэхүй лүгээ баясах хийгээд тэгш лүгээ дүрс үгүйн тэгш оролдох нугууд ба зургаан даган дурдахуйгаас барьж даган дурдахуй нугууд хийгээд мөнх бус ба зовлон лугаа би үгүйн хуран мэдэх ба би хэмээх хийгээд амьтан тэргүүтнийг хуран мэдэх лүгээ мөнх ба мөнх бус хийгээд жаргалан ба зовлон лугаа амарлисан ба эс амарлисныг хуран мэдэх хийгээд дурдатгал чухал агуулах тэргүүтэн **бодийн зүг нүгүүд** лүгээ хоосон чанар ба бэлгэ үгүй хийгээд хүсэхүй үгүй ба найман маш тонилсон хийгээд зэргээр агчийн есөн тэгш оролдох ба адхаг лугаа сэлт бөгөөд шинжлэхүйн төдий ба адхаг ч үгүй шинжлэхүй үгүйн самади лугаа хотол гарах хийгээд түрдэх ба мөр лүгээ барагдах ба үл төрөх хийгээд ном лугаа даган одох хийгээд янагуухь лугаа огоот асуух ба дуун ямар мэт мэдэгч нүгүүд хийгээд барамид ба хамаг хоосон чанар хийгээд зөн билиг нүгүүд лүгээ самади хийгээд тогтоолын үүдэн нүгүүд ба хүчин хийгээд аюул үгүй ба тус тусыг үнэхээр онох лугаа бурханы ном эс хольцсон хийгээд их нигүүлсэн ба шортбани тэргүүтний үр

лүгээ өөрийн бодь ба мөнхүү Хамаг зүйлийг айлдагч хийгээд авъяасын завсар барилдуулахын хамаг нисванисыг тэвчсэнийг бясалгах тийнхүү үл бясалгахуй нь мөнхүү билиг барамид бясалгах мөн"¹⁷. Энэхүү Билиг барамидын шастирт цувирал үгүйн дхармуудыг хязгааргүй дэлгэрүүлэн авч үзсэний дотор Бодийн зүгийг оруулжээ. Гагцхүү Бага хөлгөний Авидарма, Их хөлгөний Билиг барамидын судруудын хооронд байгаа ялгаа нь гэвэл, нэг нь бүх дхармуудыг нэг бүрчлэн тодорхойлон тайлбарлахыг гол зорилгоо болгож байхад, нөгөө нь бүх дхармын нэгдмэл чанарыг гол судлагдахуун болгосон байна.

"Бодь зүг лүгээ зохилдох гучин долоон нь дөрвөн дурдахуй ойр агуулах хийгээд дөрвөн үнэн тэвчихүй ба дөрвөн ридийн хүч хийгээд таван эрхтэн ба таван хүчин хийгээд долоон бодь гишүүн ба хутагтаны найман гишүүнт мөр болой"¹⁸ хэмээн Авидарма сурвалжид заасан буй. Дээр дурдсан анхан эртний Авидарма сурвалж болон дараа дараа үеийн Их, Бага хөлгөний бүх сурвалж Бодь зүгийн 37 ном яг л энэ дарааллаар¹⁹ байрласан байдаг.

Эдгээрээс 1 - 4 дэх ном болох Дурдахуй ойр агуулагч²⁰ гэдэг нь төрөлхтөний ой санамжаас мартагдаж гээгдэх үй түмэн зүйл байх боловч биеийг дурдах, сэрэхүйг дурдах, сэтгэлийг дурдах, номыг дурдах гэсэн дөрвөн зүйлийг байнга санан дурсахыг хэлдэг байна. Эдгээрийн утга учрын талаархи мэдлэгээ мартах нь бодгалийн доройтохын шалтгаан болно гэж үздэг. Мөрийн дээд шатанд хүрэхэд бие махбодын зүгээс үзүүлэх зөрчил, зовлонг мэдрэхгүй болох боловч ийм мэдрэхүй байдгийг зөн совингоороо шууд ойлгох чадвар нь түүний энэрэнгүй нигүүлсэхүй сэтгэл, үйл ажиллагааны хүчин зүйл болох юм. Зөвхөн биеийн зовлон төдийгүй хүний сэтгэлийн үйлчлэлийг ойлгох шаардлага тавигддаг. Гэвч энэ нь эргээд зовлонт ахуйд баригдана гэсэн үг биш бөгөөд зөвхөн тэдгээрийн үнэнхүү утгын ухаарал л яригдаж байгаа билээ. Абхидхармад номлосон амьдрал оршихуй, ухамсар сэтгэлтэй холбоотой бүхий л нэгж үзэгдлүүд буюу дхармуудыг нэг бүрчлэн илт мэдэж байх нь түгээмэл үнэнийг ухаарах нөхцөл болно.

5-8 дахь ном болох Дөрвөн үнэхээр тэвчихүй²¹ гэдэг нь нүглийн ном эс төрснийг үл төрүүлэхийн тул дуршил үүсгэх болой, нүглийн ном төрснийг тэвчихийн тул дуршил үүсгэх болой, буяны ном эс төрснийг төрүүлэхийн тул дуршил үүсгэх болой, буяны ном төрүүлсэнийг оршуулах хийгээд жич бас

төрүүлэхүй ба үл бууруулахуй хийгээд огоот төгөсгөхийн тул дуршил үүсгэх болой гэсэн дөрвөн зүйлийг агуулна. Дөрвөн үнэхээр тэвчих нь мөрийн явцад хүний сэтгэл-ухамсрын гол зорилго нь сэтгэлээ ариусгахад чиглэсэн байдаг болохыг заана. Мөрийн үйл ажиллагаа нь хамгийн эцсийн шатандаа хүртэл эргээд Сансарт оруулж болох сэтгэлийн маш нарийн хүчин зүйлд автагдах боломжтой байдаг юм. Энэ нь буянт ном буюу цувирал үгүй ном, Нирваны хүчин зүйлийг тодорхойлогч номыг улам бүр шинээр боловсруулан бүтээх тасралтгүй үйл ажиллагаа явуулна гэсэн үг. Бурхан тэнгэрүүдийн сэтгэлийн дотоод нарийн тэмцлийг буддын шашинд янз бүрээр дүрслэн илэрхийлж, бэлгэ тэмдгийн ойлголтоор гаргадаг нь цаанаа энэхүү философийн утгыг агуулж байдаг байна.

9-12 дахь Дөрвөн рид хөл²² гэдэг нь дуршихуйн самади тэвчихүй хуран үйлдэхүй лүгээ төгссөн, хичээнгүйн самади тэвчихүй хуран үйлдэхүй лүгээ төгссөн, сэтгэлийн самади тэвчихүй хуран үйлдэхүй лүгээ төгссөн, шинжлэхүйн самади тэвчихүй хуран үйлдэхүй лүгээ төгссөн дөрвөн төлвийг илэрхийлдэг. Эгэл төрөлхтөний сэтгэл нь ертөнцийн амьдралын үй түмэн асуудалд хутгалдан төөрөлдөж, эх адаггүй хөврөх элдэв бодолд дарагдан мунхарсан байдаг учраас сэтгэлийг буяны нэгэн үзүүрт бясалгалд төвлөрүүлэх үйл ажиллагааг самади (samadhi) гэнэ. Самади бясалгалаар сэтгэлийн бие даасан идэвхит чанар, сэтгэлийн хүч чадлыг илтгэх чадварыг рид хөл гэж нэрлэдэг байна. Дуршил, хичээнгүй, сэтгэл, шинжлэл гэсэн дөрвөн зүйлд төвлөрсөн бясалгалаар энэхүү хүч чадлыг олно гэж үздэг. Рид хөл гэдэгт орж байгаа “хөл” (pada, rkang-pa) гэсэн нь рид хүчний суурь, үндэс, шат гишгүүр гэсэн утгыг илэрхийлнэ. Рид хөл гэдэг бол хүний ухамсарт байхгүй онцгой чадвар гэсэн үг юм. Мөрөөр орж дээд үр дүнд хүрэхийн цагт Нирваны ахуйд улам бүр татагдан нэвтрэх чиглэлийг “дуршил” гэх ба дээр өгүүлсэн ёсоор энэ зам мөрд нь саад тотгор бологч аливаа хүчний эсрэг тэмцлээс үл уйдан сэтгэл шулуун байхыг “хичээнгүй” хэмээсэн болно. Сансрын хүрээнд сэтгэл нь хязгаарлагдмал, харьцангуй мэдлэгт үндэслэн үйл ажиллагаа явуулдаг бол мөрд орсноор сэтгэл нь ертөнцийн юмс, үзэгдэл, тэдгээрийн түгээмэл холбоо харилцаа, хөгжил хөдөлгөөний зүй тогтлын үнэн мөн чанарыг ухааран шууд мэдсэн мэдлэгт үндэслэн чанарын шинэ агуулга бүхий үйл ажиллагаа явуулдаг байна. Буддын сургаал эгэл хүнээс дээд ухамсрын төлөв байдлын оршин буй асуудлыг хөндөж тавихдаа тэдгээрийн идэвхт үйл ажиллагааг онцлон

тэмдэглэдэг ажээ.

18-23 дахь Бурханы таван эрхтэн ба Бурханы таван хүч гэдэг нь²³ зөвхөн Бурханд байх сүсэг, хичээнгүй, дуртгал, самади, билиг гэсэн таван эрхтэн буюу чадвар, тэдгээрээс илрэн гарах таван хүчин буюу үйл, үйлчлэл болой. Мөрөөр орогсдын ухамсрын энэхүү таван эрхтэн, тэдгээрийн хүчний нөлөөгөөр энэ ертөнцөд аливаа гайхамшигтай үйл явдлууд болж байдаг гэж Буддын сургаалд тайлбарладаг юм. Жишээлбэл, жирийн хүмүүсийн ухамсарт байдаг сүсэг бишрэл нь уг чанартаа бурханы сүсгийн хүчин мөн бөгөөд чухам ийм үйлчлэл үзүүлдгээрээ бурханы эрхтэний учир холбогдол гарч байгаа болно. Хүмүүсийн сүсэг ямагт ухаантан, мэргэдийн тогтоосон аугаа сургаал, номлолд үг дуугүй итгэн, сүсэглэж, улмаар номлолыг нь шашин болгон хувиргадаг. Хүмүүсийн хөдөлмөрч чанар, ой ухаан сайтай байх чанар, сэтгэн бодох чадвар зэрэг нь бурханы ухамсрын нөлөөлөл, мөрөөр орохын бэлгэдэл гэж үздэг байна. Үүгээр буддын сургаал үнэмлэхүй ухамсрыг бодит ахуйтай нэгтгэн тайлбарладаг юм.

Бодийн долоон гишүүн хэмээх 23-29 дэх ном нь²⁴: дурьдахуй үнэхээр бодийн гишүүн, номыг сайтар ялгагч үнэхээр бодийн гишүүн, хичээнгүй үнэхээр бодийн гишүүн, баясгалан үнэхээр бодийн гишүүн, маш судалсан үнэхээр бодийн гишүүн, самади үнэхээр бодийн гишүүн, тэгш үнэхээр бодийн гишүүн –эдгээр долоон ном болой. Өнгөрсөн, одоо, ирээдүй цагийн хамаг номыг үл мартан, санан дурсаж байдаг, тэдгээрийн ялгаатай ба нэгдмэл талыг ухаарсан, үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулдаг, амгалан тайван байдал нь хямрал зөрчилгүй учраас сэтгэл хангалуун байж чаддаг, бүхнийг сайтар тунгаан мэдсэн, сэтгэлийн өчүүхэн ч хөдөлгөөнгүй нэгэн үзүүрт төвлөрсөн, дээр доор, хол ойрын ялгалгүйгээр бүхнийг тэгш үздэг бурханы сэтгэлийн долоон гол шинжийг энд заажээ.

Бодь буюу сансраас ангижирсан ухамсрын төлвийн асуудлыг энэхүү долоон тал шинжээр тодорхойлон гаргахдаа дээр нэгэнт тайлбарласан дуртгал, хичээнгүй, самади зэргийг түүний салшгүй чанар болгон авч үзжээ. Юуны өмнө дуртгал номыг маш тийн ялгах гэдэг нь ой санамжид хадгалагдан байгаа ертөнцийн түгээмэл холбоо харилцааны багтаамж нь хязгааргүй боловч тэр бүрийг өөр хооронд нь холилгүй, бүрхэгдүүлэлгүй, эмх цэгцийг нь алдагдуулалгүй, яг байгаагаар нь баттай тодорхой санах, тодорхойлох чадварыг тэмдэглэсэн байна. Хүмүүс практик болон танин мэдэхүйдээ сонирхож байгаа юмс үзэгдлээ шинж чанараар нь ялган, сэтгэл

бодолдоо тодорхойлдог билээ. Харин дуртгал номыг машид тийн ялгаснаар аль нэг тодорхой сонирхогдсон юм үзэгдэл бус, бүх ертөнцийн уялдаа холбоо, хөгжил хөдөлгөөний нэгдмэл урсгалыг танин барих боломжтой болдог байна. Сонирхол нь зөвхөн зөрчил, хүсэл тэмүүллийг төрүүлдэг, иймээс ч цувиралт ном болдог юм. Харин дуртгал номыг машид тийн ялгахуй нь цувирал үгүйн ном, тиймээс түгээмэл үнэмлэхүй асуудлыг л авч үзнэ.

“Баясгалан” гэсэн сэтгэл-ухамсрын төлвийг цувирал үгүй номын хүрээнд авч үздгийн учир нь мөрөөр орсон ухамсарт уурлах, хилигнэх, атаархах, ундууцах, гоморхох, уйтгарлах зэрэг сэтгэлийн сөрөг үзэгдлүүд бүрмөсөн дарагдсан байдаг бөгөөд энэ бүх сэтгэл хөдлөлийн оронд баясгалан гэсэн цорын ганц төлөв үлддэгийг заасан болно. Гэхдээ энэхүү баясгаланг омог, дээрэнгүй, бахархалаас ялгах хэрэгтэй юм. Ер нь сэтгэл хөдлөлийн үзэгдлүүд нь ертөнцийн аливаа юм үзэгдэлд хандах хүний хандлагаар тодорхойлогддог. Тэрээр хувь хүний онцлог шинжийг илэрхийлж байдаг дотоод толь мөн гэж сэтгэл судлалд үздэг билээ. Абхидхарма философид баясгалан бол бүх сөрөг сэтгэл хөдлөлүүдийг гаргахааргүй ухамсрын тийм нарийн түвшинд хүрсэн үеийн сэтгэлийн цорын ганц илрэл болохыг заадаг. Энэ бол сэтгэлийн тайван амгалан байдал мөн боловч идэвхгүй, унтарсан төлөв бус, харин сэтгэлийн хангалуун, ханамжтай байдал юм.

“Маш судалсан” гэсэн төлөв нь бүх юм үзэгдлийн мөн чанарыг ухаарсан, ертөнцийн түгээмэл үндсийг тал бүрээс нягтлан судалж, эцсийн үр дүнд хүрснийг илэрхийлэх шинж болно. Хэрвээ шинжлэх ухаан нь байгаль, нийгэм, сэтгэлгээний тухай шинэ мэдлэг бий болгоход чиглэсэн үйлдвэрлэлийн бүх нөхцөл, талыг багтаасан судалгааны үйл ажиллагаа байдаг бол “маш судалсан” нь цааш шинэ мэдлэг рүү тэмүүлэх хүсэл, шунал хаагдах үндэс болж, мэдлэгийн хэрэгцээний дээд туйл гэсэн утгыг илтгэнэ.

Нэгэнт бүхний үндэс тодорхой болж ухаарагдсан байх тул аль нэг тусгаар юм үзэгдлийг түгээмэл холбооноос нь салган илүүд үзэх, эсвэл дутууд үзэх, сайн муу хэмээн ялгах, тустай тусгүй хэмээн зэрэг дэв тогтоох сэтгэл ухамсрын үндэс ч дарагддаг юм. Сэтгэлийн энэ талыг Абхидхарма философид “Тэгш” гэсэн ойлголтоор тэмдэглэдэг. Тэгшийн тухай асуудал улмаар Их хөлгөний философийн хоосон чанарын асуудалд холбогдон ертөнцийн бүх юм үзэгдлийн тэгш чанарыг илэрхийлэх болсон байна.

Сүүлчийн 30-37 дахь хутагтын Найман гишүүнт мөр²⁵ гэдэг нь: үнэхээр үзэл, үнэхээр онол, үнэхээр үгс, үнэхээр хичээл, үнэхээр амьдрал, үнэхээр дурьдахуй, үнэхээр самади, үнэхээр үйлийн хязгаар болой. Хүмүүсийн ертөнцийг үзэх үзэл нь ямагт тодорхой хүчин нөхцлөөр бүрэлдсэн, харьцангуй утгатай байх тул эргээд ертөнцийн үнэмлэхүйн үүднээс зөрчилт үзэл, зовлон болдог. Харин бүх ертөнцийн түгээмэл холбоо харилцааг ухаарсаны үүднээс ертөнцийг үзэх нь үнэн үзэл болно. Энэхүү үнэн үзэл нь онолын түвшинд үндэслэгдсэн байхыг үнэн онол гэнэ. Үнэн онолыг номлоход ямагт хамгийн зөв зохистой үг хэллэгийг ашиглах бөгөөд ийнхүү үнэн онол, үнэн үзлийг илэрхийлж байгаа үг хэллэгийг үнэн үг хэмээсэн болно. Аливаа үйл ажиллагаа нь ямагт үр дагаврыг төрүүлж байдаг бөгөөд зовлон, зөрчилт харилцааг нэгэнт дахин үүсэхээргүй тийм үйл ажиллагаа бол үнэн үйлийн хязгаар юм. Амьдрал ахуй, сэтгэл ухамсраа зөв жолоодон, дээд хэмжээнд бясалгал явуулах боломж олохын гол нөхцөл нь үнэн тэжээл буюу тулын эрүүл мэнд гэж үздэг байна. Дээд төлөвт хүрсэн ухамсар гэдэг бол ямагт идэвхтэй, эцсийн зорилгодоо тууштай хүрэх байр суурийг баримтлахыг “үнэн хичээл”, бясалгал явуулах үед ой ухаандаа ертөнцийн түгээмэл учир зүй, үндэс язгуур, бүхний нэгдмэл бодит байдлыг багтаан ухварлаж чадаж байхыг “үнэн дуртгал”, бодрол оюунаа зөвхөн нэгэн зүйлд төвлөрүүлэн ариусгахыг “үнэн самади” хэмээн тус тус нэрлэжээ.²⁶

Бодь зүгийн 37 номыг илүү бүдүүвчлэн ангилах явдал бүр эрт үеэс бий болжээ. Тухайлбал манай тооллын өмнөх үеийн Авидарма сурвалжуудаас хамгийн алдартай Mahāvibhāṣā сударт: “Бодь зүгийн 37 номын дотроос бодийн долоон гишүүний талаар Āgama-нуудад тодорхой заасан буй. 37-оос 11, эсвэл 12 дахь гишүүн нь хамгийн гол гишүүн болно. 37 гишүүн нь 7 хэсэг болж бүлэглэн дугаарлагддаг”²⁷ гэжээ. Харин сүүл үеийн Их хөлгөний Авидарма сурвалжид бодь зүгийн 37 номыг арван бүлэгт хураасан буй: “Нэрийн үүднээс бодь зүг лүгээ зохилдох гучин долоон хэмээх, эд дор арван, бодь зүг лүгээ зохилдох бүгд нь эд дор арван буюу. Арван аль буй хэмээвээс [1] сүсэг хийгээд [2] хичээнгүй, [3] дуртгал ба [4] билиг, [5] самади, [6] тэгш, [7] баясгалан, [8] онол хийгээд [9] шагшаабадь, [10] маш судалсан, тэр мэт үйлдвээс тэдгээр нь эд дор арван болой. Хэр мэт үйлдмү хэмээвээс дурдахуй ойр агуулах нь билиг буюу. Хичээнгүй, үнэн агуулах буюу рид хөл нь самади болой. Дурдахуй ойр агуулах хийгээд үнэн маш агуулах ба ридийн хөл нүүгүүд нь билиг хийгээд хичээнгүй ба самадийн

чанар мөн болой. Тиймийн тул хоромхоноо эрхтэн хийгээд хүчин нүгүүд нь нэрээр өгүүлсэн нь сүсэг хийгээд хичээнгүй ба дурдахуй хийгээд самади ба билгийн таван эд мөн буюу. Дурдахуй ойр агуулах хийгээд номыг маш ялгах үнэн бодийн гишүүн ба үнэн үзэл нь ямагт билиг мөн болой. Үнэн маш агуулах хийгээд хичээнгүй үнэн бодь гишүүн лүгээ үнэн хичээл нь ямагт хичээнгүй мөн болой. Ридийн хүч нүгүүд хийгээд самади үнэн бодь мөч лүгээ үнэн самади нь ямагт самади мөн болой. Дурдахуй үнэн бодь мөч хийгээд үнэн дурдахуй нь ямагт дурдахуй мөн болой. Хэн нэгэн хоцорсон буюу хэмээвээс баясгалан хийгээд маш судалсан ба тэгш үнэн бодь мөч хийгээд үнэн онол ба шагшаабацийн мөч нүгүүд лүгээ эд таван буюу. Тэр мэт бөгөөс бодь зүг лүгээ зохилдох тэдгээр нь арван эд болой"²⁸ гэжээ.

Буддын сурвалжуудад Бодь зүгийн 37 номыг Буддын дөрвөн үнэнээс сүүлчийн буюу Мөрийн үнэнд хамааруулан авч үздэг²⁹. Мөрөөр орж бясалгалд суралцан дээд үр дүнд хүрч эхлэхэд Буддын сургаалын дөрвөн үнэнийг чанарын шинэ түвшинд ухаарах ба үнэн тус бүрийн хүрээнд боловсрох философийн шинэ ойлголтууд, шинэ номуудыг заагаад эдгээрээс Түрдэхүйн үнэнд хамаарах номуудад Бодь зүгийн номууд багтана гэж үздэг байна³⁰.

Бодь зүгийн 37 ном нь Их хөлгийн Үзэхүй мөрөөс эхлэн илэрч, улмаар Бурханы шинж болж хөгжих тухай сурвалжид заасан байдаг: "Тэр мэт суралцваас дурдахуй чухал агуулах тэргүүтэн бодь зүг огоот төгссөнөөр Үзэхүй мөр хийгээд мөнхүү Хамаг зүйлийг айлдагчийн бэлгэ билиг огоот төгсөхүй хүртэл бээр бясалгахын мөр мөн бөгөөд тэр мэт бод үгүйн мөн чанар мөн хэмээн дуусавч Зэргээрийн үйл тэргүүтнийг сайтар мэдэгч нь Бурханыг даган дурдах бясалгалаа онон үйлдэх болой"³¹. Ерөөс эх сурвалжуудад Бодь зүгийн 37 ном нь дээд хутагтын чанар гэж тайлбарласан байдаг. Эртний Энэтхэгийн Авидарма долоон үндсэн судрын нэгэн болох "Номын цогц" хэмээх сурвалжид: "Сайн бодгаль (satpuruṣa) гэж шунал хүсэл, атаа жетөө, мунхаг харанхуйгаас гэтэлж бүх төрөлхтөнд сургаалаа айлдагч Бурханыг, түүний шагшаабацийг дагагч шавь нарыг, сайн номыг, бодь зүгийн 37 ном тэргүүтнийг хэлнэ"³² гэсэн бол Билиг барамидын сударт: "Билиг барамидыг сонсох, үзэх, мөргөх, сөгдөх, барих, тогтоох, унших, хотлыг дотроо оруулах, сайтар... уншихын тулд тэнд ... билиг барамидын дууг сонсох болмуй, бодь зүгийн номуудыг сонсмуй, бодь моддыг үзмүй"³³ гэсэн байдаг.

Ийнхүү Эртний Ведийн үеийн Энэтхэгт “гүн нарийн сэтгэлгээ” гэсэн утгаар хэрэглэгдэж байсан “Бодь” гэсэн ойлголт Буддын сургаалд эгэл төрөлхтний ухамсрын төлвөөс чанарын ялгаатай, чинад хязгаарт хүрсэн “дээд билиг” гэдэг утгыг заах болж, бодгалийг бүрдүүлэгч зайлшгүй чанарын буюу дхармуудын тоонд түүнийг багтаан номлохдоо гагцхүү өөрийн бэлгэ чанарыг нь тодорхойлох ба нэгдэлд нь ухаарахын ялгаа Бага ба Их хөлгөний Буддизмд илэрдэг байна.

Ишлэл зүүлт

¹ Rigveda V. 75-5; vol. iii, p.530

² Sanskrit Dictionary. M.W.

³ Har Dayal. The Boddhisattva Doctrine in Buddhist Sanskrit Literature. Delhi 2004. p.19

⁴ Вимуктасена. Илт онолын чимэгийн тайлбар. Улаанбаатар 2004. х.320

⁵ H. Oldenberg. The Doctrine of the Upanisads and the early Buddhism. Delhi 1977. p.202-212

⁶ Васубанду. Авидармакошагийн тайлбар. Монгол Данжуур. Боть 152. х. 53А-Б

⁷ Буддын шашин-соёлын тайлбар толь. I дэвтэр. Улаанбаатар 1999. х.145

⁸ Вимуктасена. Илт онолын чимэгийн тайлбар. Улаанбаатар 2004. х.269

⁹ Har Dayal. The Boddhisattva Doctrine in Buddhist Sanskrit Literature. Delhi 2004. p.80-81

¹⁰ Вимуктасена. Илт онолын чимэгийн тайлбар. Улаанбаатар 2004. х.296

¹¹ Васубанду. Авидармакошагийн тайлбар. Монгол Данжуур. Боть 151. х.57А

¹² Найман мянгат Их хөлгөн судар оршивой. Адмон Хэвлэх Үйлдвэр. Х.33

¹³ Вимуктасена. Илт онолын чимэгийн тайлбар. Улаанбаатар 2004. х.75-76

¹⁴ Linnart Mdl. Studies in the Aṣṭasāhasrikā Prajāpāramitā and other essays. Delhi 2005. p.39-43

¹⁵ М.Гантуяа. Билиг барамидын философи үзэл. Диссертаци. УБ. 1995. Хоёрдугаар бүлэг.

¹⁶ Encyclopedia of Indian Philosophies. Volume VII. Abhidharma Buddhism to 150 A.D. Delhi 1998. p.373

¹⁷ Вимуктасена. Илт онолын чимэгийн тайлбар. Улаанбаатар 2004. х.285

¹⁸ Васубанду. Авидармакошагийн тайлбар. Монгол Данжуур. Боть 152. х.53А

Монгол	Санскрит	Төвд	Англи
Бодь зүгийн 37 ном: 1-4. Дөрвөн дурдахуй ойр агуулагч, 5-8. Дөрвөн үнэхээр тэвчихүй, 9-12. Дөрвөн рид хөл, 13-17. Бурханы таван эрхтэн, 18-22. Бурханы таван хүч, 23-29. Бодийн долоон гишүүн, 30-37. Найман гишүүнт мөр	Saptatrimśat Bodhipakṣaka dharma: 1-4. smṛty Upasthānāni, 5-8. samyak prahāṇāni, 9-12. rddhipādāḥ, 13-17. indriyāni, 18-22. balāni, 23-29. bodhyaṅgāni, 30-37. mārgaṅgāni	Byang-chub-phyogs- gyi-chos-so-bdug: 1-4. dran-pa-nye-bar- bzhag-pa-bzhi, 5-8. yang-lag-par- spong-ba-bzhi, 9-12. rdzu-'phrul-gyi- rkang-pa-bzhi, 13-17. dbang-po-linga 18-22. stobs-linga, 23-29. byang-chub- phyogs-kyi-chos- bdun, 30-37. 'phags-lam- yan-lag-brgyad	The 37 Limbs of (the 37 Auxiliaries to): Enlightenment: 1-4. 4 close contemplations, 5-8. 4 perfect abandonments, 9-12. 4 limbs of miracles, 13-17. 5 powers, 18-22. 5 forces, 23-29. 7 limbs of enlightenments, 30-37. 8 noble paths

Дөрвөн дурдахуй ойр агуулагч: 1. Биеийг дурдахуй ойр агуулагч 2. Сэрэхүйг дурдахуй ойр агуулагч 3. Сэтгэлийг дурдахуй ойр агуулагч 4. Номыг дурдахуй ойр агуулагч	Catvari smṛity- ūpasthāna: 1. kāya smṛity- ūpasthāna 2. vedana smṛity- ūpasthāna 3. citta smṛity- ūpasthāna 4. dharma smṛity- ūpasthāna	dran-pa-nye-bar- bzhag-pa-bzhi: 1. lus-dran-pa- nyer-bzhag 2. cshor-ba-dran- pa-nyer-bzhag 3. sems-dran-pa- nyer-bzhag 4. chos-dran-pa- nyer-bzhag	The four close contemplations: 1. close contemplation of body 2. close contemplation of feelings 3. close contemplation of mind 4. close contemplation of dharma
--	--	---	---

Дөрвөн үнэхээр тэвчихүй: 1) нүгэлийн ном эс төрснийг үл төрүүлэхийн тул дуршил үүсгэх болой 2) нүгэлийн ном төрснийг тэвчихийн тул дуршил үүсгэх болой 3) буяны ном эс төрснийг төрүүлэхийн тул дуршил үүсгэх болой 4) буяны ном төрүүлсэнийг оршуулах хийгээд жич бас төрүүлэхүй ба үл бууруулахуй хийгээд огоот төгөсгөхийн тул дуршил үүсгэх	Yang-dag-sbong-ba-bzhi 1.mi-dge-ba-ma-skyes-pa-sbong-ba 2.mi-dge-ba-ma-skyes-pa-mi-bskyed-pa-sbong-ba 3.dge-ba-skyes-pa-srel-ba 4.dge-ba-ma-skyes-pa-bskyed-pa	Four perfect abandonments: 1. Abandonment of non-virtues that have been produced 2. Non-generation of non-virtues that have not yet been produced 3. Increase of virtues that have been produced 4. making effort in generation virtues that have not yet been produced
--	--	---

Дөрвөн риди хөл: 1) дуршихуйн самади тэвчихүй хуран үйлдэхүй лүгээ төгссөн (с.т.х.ү.л.т) 2) хичээнгүйн с.т.х.ү.л.т. 3) сэтгэлийн с.т.х.ү.л.т. 4) шинжлэхүйн с.т.х.ү.л.т.	Catvari riddhipāda: 1.chanda 2.vīrya 3.citta 4.mīmamsā	rDzu-'phrul-gyi-rtang-pa-rnam-par: 1.'dun-pa'l-de 2.brtso-'grus-hyi-de 3.bsam-pa'l-de 4.dbyod-pa'l-de	Four limbs of miracles: 1.that of aspiration 2.that of perseverance 3.that of thought 4.that of analysis
---	--	---	--

Таван эрхтэн: 1. Сүсгийн эрхтэн 2. Хичээнгүйн э. 3. Дурьдахуйн э. 4. Самадийн э. 5. Билгийн э.	Pacca indriya: 1.śraddha indriya 2.vīrya indriya 3.smṛti indriya 4.samādhi indriya 5.prajñā indriya	DBang-po-rnam-par: 1.dad-pa'l-dbang-po 2.brtson-'grus-kyi-dbang-po 3.dran-pa'l-dbang-po 4.ting-nge-'dzin-gyi-dbang-po 5.she-rab-kyi-dbang-po	The five powers: 1.power of faith 2.power of effort 3.power of mindfulness 4.power of concentration 5.power of wisdom
--	--	---	--

Таван хүчин:	Paṇca bala:	STobs-rnam-par:	The five forces:
1. Сүсгийн хүч	1.śraddha bala	1.dad+pa'l-stobs	1.force of faith
2. Хичээнгүйн х.	2.vīrya bala	2.brtson-'grus-kyi-stobs	2.force of effort
3. Дурьдахуйн х.	3.smṛiti bala	3.dran-pa'l-stobs	3.force of mindfulness
4. Самадийн х.	4.samādhi bala	4.ting-nge-'dzin-gyi-stobs	4.force of
5. Билгийн х.	5.prajcā bala	5.she-rab-kyi-stobs	5.concentration power of wisdom

24

Долоон Бодь гишүүн:	Sapta bodhyāṅga:	Byang-chub-kyi-yang-lag-rnam-par:	Seven limbs of Enlightenment:
1.дурьдахуй үнэхээр бодийн гишүүн	1.smṛiti	1.dran-pa-byang-chub-kyi-yang-lag	1.mindfulness
2.номыг сайтар ялгагч үнэхээр бодийн гишүүн	2.dharma pravacaya	2.shos-rab-tu-rnam-'byed-byang-chub-kyi-yang-lag	2.wisdom
3.хичээнгүй үнэхээр бодийн гишүүн	3.vīrya	3.brtson-'grus- byang-chub-kyi-yang-lag	3.effort
4.баясгалан үнэхээр бодийн гишүүн	4.prīti	4.dga'-ba-byang-chub-kyi-yang-lag	4.joy
5.маш судалсан үнэхээр бодийн гишүүн	5.praśrabdhi	5.shin-spyangs-byang-chub-kyi-yang-lag	5.suppleness
6.самади үнэхээр бодийн гишүүн	6.samādhi	6.ting-'dzin-byang-chub-kyi-yang-lag	6.concentration
7.тэгш үнэхээр бодийн гишүүн	7.upekṣā	7.dtang-snyoms-byang-chub-kyi-yang-lag	7.equanimity

25

Хутагтын 8 гишүүнт мөр:	aṣṭāryamārga:	'phags-pa'l-lam-yan-lag-brgyud-pa-rnam-par:	Eighth Noble Paths:
1. үнэхээр үзэл	1.samyak dṛiṣṭi	1.yang-dag-pa'l-lta-pa	1.right view
2. үнэхээр онол	2.samyak samkalpa	2.yang-dag-pa'l-rtogs-pa	2.right thought
3. үнэхээр үгс	3.samyak vāk	3.yang-dag-pa'l-dag	3.right speech
4. үнэхээр хичээл	4.samyak vyāyāma	4. yang-dag-pa'l-rtso-ba	4.right effort
5. үнэхээр амьдрал	5.samyak ajiva	5.yang-dag-pa'l-'tsho-ba	5.right livelihood
6. үнэхээр дурьдахуй	6.samyak smṛiti	6.yang-dag-pa'l-dran-ba	6.right mindfulness
7. үнэхээр самади	7.samyak samādhi	7.yang-dag-pa'l-ting-nge-'dzin	7.right concentration
8. үнэхээр үйлийн хязгаар	8.samyak karmāṅta	8.yang-dag-pa'l-las-mba'	8.right action

²⁶ М.Гантуяа. Абхидхарма философи. Лекцийн эмтхгэл. Улаанбаатар 2000. Хорин зургадугаар лекц. Бодь зүгийн гучин долоон ном. Х.201-207

- ²⁷Encyclopedia of Indian Philosophies. Volume VII. Abhidharma Buddhism to 150 A.D. Delhi 1998. p.55
- ²⁸Васубанду. Авидармакошагийн тайлбар. Монгол Данжуур. Боть 152. х.53-54
- ²⁹Васубанду. Авидармакошагийн номлолоос Мөр хийгээд Бодгаль үзүүлсэн нэрт сангийн Зургадугаар орон. Монгол Данжуур. Боть 152. х.53-57
- ³⁰Вимуктасена. Илт онолын чимэгийн тайлбар. Улаанбаатар 2004. х.179
- ³¹Вимуктасена. Илт онолын чимэгийн тайлбар. Улаанбаатар 2004. х.289
- ³²Encyclopedia of Indian Philosophies. Volume VII. Abhidharma Buddhism to 150 A.D. Delhi 1998. p.180
- ³³Найман мянгат Их хөлгөн судар оршвой. Адмон хэвлэх үлдвэр. Х.81-82

Summary

The word "Bodhi" means an enlightenment or a liberation, a perfect knowledge or a perfect wisdom, the result of Paths final stage. There are very many categories connected to the "Bodhi" one of which is Bodhipakṣaka dharma. Amount of Abhidharma and Prajnaparamita literature are mentioned about Bodhipakṣaka dharma. This word means the qualities or items constituting or contributing to Enlightenment or Liberation. The main purpose of Buddhist doctrine is revilement of Bodhipakṣaka qualities in People mind.

The 37 Limbs of (the 37 Auxiliaries to) Enlightenment by Buddhist Doctrine are analyzed in the Article:

1-4. Four close contemplations: close contemplation of body, of feelings, of mind and close contemplation of dharma

5-8. Four perfect abandonments: abandonment of non-virtues that have been produced, non-generation of non-virtues that have not yet been produced, Increase of virtues that have been produced, and Making effort in generation virtues that have not yet been produced

9-12. Four limbs of miracles: Miracle of aspiration, of perseverance, of thought, and Miracle of analysis

13-22. Five powers and five forces: Power and Force of faith, of effort, of mindfulness, of concentration, and power and force of wisdom

23-29. Seven limbs of Enlightenment: mindfulness, wisdom, effort, joy, suppleness, concentration, and equanimity

30-37. Eighth Noble Paths: right view, right thought, right speech, right effort, right livelihood, right mindfulness, right concentration, and right action